

ХҮҮХДИЙН СҮҮН ТЭЖЭЭЛИЙН ҮЙЛДВЭРИЙН

ТОВЧ ТАНИЛДУУЛГА

1971-1985

Улаанбаатар хотын Хүүхдийн Сүүн Тэжээлийн Үйлдвэр нь 1971 онд байгуулагдсан. Тус үйлдвэрийг 1971 онд ардын хувьсгалын 50 жилийн ойг тохиолдуулан ЗХУ-ын ард түмнээс манай улсад бэлэглэсэн юм.

Тус үйлдвэр нь хоногт 5 тонн сүү хүлээн авч боловсруулан 0-I насны хүүхдэд нэг уух хэмжээгээр нь савлаж/200 граммаар/ 25000 нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргах төслийн хүч чадалтай.

Хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэр нь одоо жилд 7,0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 7,6 сая төгрөгийн бараа борлуулалт хийж байна.

Тус үйлдвэр нь жилд 4 сая литр сүү хүлээн авч боловсруулан гол нэр төрлөөр 2,8 сая литр ариутгасан сүү, 0,7 сая тонн тараг, 58 тонн хүүхдийн будаа, 75 мянган литр врис, 20 тонн ээдэм үйлдвэрлэж байна.

Тус үйлдвэр нь дорхи үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.

1. Сүү хүлээн авах хэсэг
2. Сүүт савлаж, ариутган боловсруулах, хөргөх хэсэг
3. Холимог сүү, ээдэм, хүүхдийн нэмэгдэл хоол тэжээл үйлдвэрлэн савлах хэсэг
4. Тараг үйлдвэрлэх хэсэг
5. Шил, сав хэрэглэл сүүний сетик угааж ариутгах хэсэг
6. Лаборатори
7. Сантехник, нахилгаан, механикийн засварын хэсэг

Мөн 1987 онд НҮЕ-ын тусламжаар баригдсан хүүхдийн хуурай хоол тэжээлийн цех ашиглалтанд орж эхийн сүүтэй төстэй хуурай сүүн тэжээл үйлдвэрлэж байна.

Хүүхдийн Сүүн Тэжээлийн Үйлдвэр нь ариутгасан сүү, врис, тараг, ээдэм, ногооны нухашнууд, лувантай ээдэм, хүүхдийн ба цагаан будааны агшаамал, тэжээллэг зутан, хуурай сүүн тэжээл зэрэг 10 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж хөдөлмөрчдийн хэрэгцээнд нийлүүлж байна.

Тус үйлдвэрээс гарч байгаа бүх бүтээгдэхүүн нь үйлдвэрийн лабораторийн шинжилгээ хийгдэж, хүүхдэд өгч болно гэсэн шинжилгээний үндсэн дээр Улаанбаатар хотын 4 районд байрласан сүү түгээх 16 салбараар дамжин хэсгийн эмч нарын сичгийн дагуу эцэг эхчүүдийн гар дээр өгдөг юм. Мөн Улаанбаатар хотын яслиудын системүүд, хүүхдийн больницууд, районуудын сургууль цэцэрлэгүүдийн нэгдсэн аж ахуйн төвүүд, хүүхдийн сувилалын газрууд зэрэг хүүхдийн болон эмнэлгийн нийт 30 шахам байгууллагад тэдний захиалгын дагуу аж

ахуйн гэрээ байгуулан сүү, сүүн бүтээгдэхүүн, нэмэгдэл хоол тэжээлээр үйлчилж байна. Манай үйлдвэрээс гарч байгаа бүх бүтээгдэхүүн нь бүрэн боловсрогдон ариутгасан байдаг учраас дахин боловсруулалт хийх шаардлагагүй шууд хүүхдэд өгдөгөөрөө онцлог юм.

Тус үйлдвэр нь 1973 онд 2,8 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан бол 1975 онд 3 сая төгрөг, 1980 онд 3,7 сая төгрөг, 1985 онд 5,6 сая төгрөг, 1987 онд 7,0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж үйлдвэрлэх хүчин чадал жилээс жилд нэмэгдэж байна.

Хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэр нь ЗХУ болон өөрийн орны их дээд сургууль, техникум, техник мэргэжлийн сургууль төгссөн мэргэжилтэй ажилчид, инженер техникийн ажилтнаар бүрэн хангагдсан юм.

Одоо тус үйлдвэр нь 100 гаруй ажиллагсадтай түүний 90 шахам хувь нь залуучууд, 80 шахам хувь нь эмэгтэйчүүд, 50 гаруй хувь нь нам, эвлэлийн гишүүд, 20 гаруй хувь нь дээд, тусгай мэргэжлийн боловсролтой ажилчин, албан хаагчид байна.

Нам засгаас эх нялхсын эрүүл мэндийг хамгаалах талаар үргэлж анхаарал халамж тавьж байдгийн нэг илрэл нь 1990 онд ашиглалтанд орох ЗХУ-ын техникийн тусламжаар баригдах Хүүхдийн Сүүн Тэжээлийн шинэ үйлдвэр юм. Шинэ үйлдвэр ашиглалтанд орсноор үйлдвэрлэлийн хүчин чадал 2 дахин нэмэгдэж, ажиллагсдын тоо үлэмж өсөх юм.

Хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэрийн товч танилцуулга

1971 — 2000

Тус үйлдвэр нь 1971 онд Зөвлөлтийн ард түмнээс манай орны ардын хувьсгалын 50 жилийн ойг тохиолдуулан бэлэг болгон ашиглалтанд оруулж өгснөөс хойш эдүгээ 29 жил болж байна.

Хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэр нь байгуулагдсан цагаас хойш нийслэл хотын үр хүүхдийг эрүүл энх өсч бойжиход тодорхой хувь нэмрээ оруулж ирсэн түүхтэй.

1995 оныг хүртэл хоногт 5 тн сүү боловсруулж, 25000 нэгж бүтээгдхүүнийг 200 гр – аар савлаж нийслэлийн 10 мянга гаруй хүүхдэд өдөр бүр үйлчилэхийн зэрэгцээ 30 гаруй ясли, 5 хүүхдийн больницыг сүү тараг бусад бүтээгдэхүүнээр тасралтгүй хангаж байсан бөгөөд тэр үеийн манай үйлдвэрийн бүтээгдэхүүний чанар хангамжийг нийслэлийнхэн хараахан мартаагүй байгаа гэдэгт найдаж байна.

Хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэр нь анх ашиглалтанд орохдоо түүхий эдийг УБ хотын сүүний үйлдвэрээс хангахаар бодож зохион байгуулагдсан. Гэтэл хот тойрсон сүүний фермүүд олноор тарж бутарч сүү нийлүүлэлт нь эрс багасч сүүний үйлдвэр манай үйлдвэрийг байтугай өөрийгөө ч сүүгээр хангах чадваргүй болж бид 1994 оноос өөрсдөө сүүгээ олж нийлүүлэн үйлдвэрлэлээ явуулж байна.

Дээрх байдлаас шалтгаалан 1993 оноос сүү хүлээн авалт 3.5 – 12 дахин буурч түүнийг дагаж бүтээгдэхүүн үйлдвэрлэл мөн төдий чинээ буурлаа. 1995 – 2000 хүртэл хугцаанд хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэр өвлийн улиралд өдөрт 500 – 600 л зуны улиралд 2000 – 3000 л сүү хүлээн авч боловсруулан 1998 оны байдлаар жилд 237 тн ариутгасан 127 тн тараг 0.8 тн ээдэм, 0.8 тн нарийн боов 262.4 мянган ширхэг зайрмаг 0.3 тн цөцгий үйлдвэрлэж 321 тн сүү хүлээн авч боловсрууллаа.

Энэ нь 1991 оны мөн үеийнхээс сүү хүлээн авалт 15 дахин, ариутгасан сүү үйлдвэрлэлт 16 дахин, тараг үйлдвэрлэлт 6 дахин буурсан дүн гарч байна.

Иймд цаашид уг үйлдвэрийг хэвийн ажиллагаагаар хангахын тулд дор дурдсан арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Үүнд:

1. Үйлдвэрийг баталгаатай түүхий эдийн баазтай болгож, бусдийн хараат байдлаас гаргахын тулд өөрийн үнээний фермтэй болгох

2. Хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэрийг өөрөө өөрийгээ санхүүжүүлж улсаас алданги авахгүйгээр бие даан ажиллах санхүүгийн чадавхитай болгохын тулд эхний ээлжинд урт хугацаны хөнгөлөлттэй зээл олгох талаар холбогдох багууллагуудтай хамтран шийдвэрлэж, 1996 онд бидний боловсруулан Нийслэлийн засаг даргад өргөн барьсан "Жавхлан" "Сургуулийн насны хүүхдийн хоол тэжээл" "Хүүхдийн тэжээл" нэртэй төслүүдийг бүхий л талаар дэмжин санхүүжүүлэхэд тодорхой тусламж үзүүлэх

3. Үйлдвэрийн шинэ удирдлага ажил хүлээн авсан цагаас хойш үйлдвэрийн техник технологийг шинэчлэн өөрчлөх талаар анхаарч гадаадын хөрөнгө оруулагчийн идэвхэй эрэлхийлсний дүнд Данийн Ниро компани Гордик сантай хамтран 1 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийх боломжтой болох албан мэдэгдэл аваад байна .

Үүний зэрэгцээ Шведийн Альфа Лавал Корпоцийн Гонгонг дахь салбараас манай үйлдвэрт хөрөнгө оруулах боломжийг судалж эхний ээлжийн уулзалтуудийг хийгээд байна .

Дээрхи дэлхийн алдартай корпорциудийн хэрэв манай үйлдвэрт хөрөнгө оруулбал нийслэлийн бүх насны хүүхдийн тэжээлийн асуудлыг иж бүрнээр нь шийдвэрлэх боломжтой болохын зэрэгцээ хүүхдийн тэжээл үйлдвэрлэлийн техник технологийн түвшинг үндсээр нь өөрчлөх болно.

Иймд тэдгээр хөрөнгө оруулагчдыг дэмжих асуудалд хотын захиргаа бүх талын туслалцаа үзүүлэх

4. Тус үйлдвэр нь барилга сантехникийн засвар ашиглалтанд орсон цагаасаа хойш хийгдээгүй тул материалын гүн элэгдэлд орж цаашид үйлдвэрлэл явуулахад хүндрэл учруулж байгаа бөгөөд 200 м дулааны хос шугам солих , барилгын бүрэн засвар хийхэд нийт 10 сая төгрөг эхний ээлжинд зайлшгүй хэрэгцээтэй байна .

Иймд Хотын захиргаа өөрийн эрх мэдлийн хүрээнд уг асуудлыг авч хэлэлцэн хөрөнгийн эх үүсвэрийн гаргаж өгөх талаар шийдвэрлэх


5. Хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэр анх байгуулагдахдаа сүүний үйлдвэрээс сүү авахаао тооцоологдсон тул өөрийн зориулалтын машин байхгүйгээс дуудлагын унаа авч сүүгээ нийлүүлж байгаагаас зардал өндөрсөж алдагдал нэмэгдэж байна.

Гэтэл одоо сүүний үйлдвэрт 10 гаруй сүү тээвэрлэх зориулалтын машин ашиглагдаж байгаа бөгөөд одоогоор тэдгээрийн 7 машин ашиглалтгүй сул байна . Иймд манай үйлдвэрийн үйл ажилгааг дэмжих , гадаадын тусламж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор ХСТҮ – т 2 машин ашиглуулах асуудлыг Төрийн өмчийн хороотой хамтран шийдвэрлэх

Дээрхи арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр нийслэлийн хүүхдийн хоол тэжээлийн үйлдвэрлэлийн техник технологийн үндсээр нь өөрчлөн шинэ төвшинд хүрэхийн зэрэгцээ манай орны үр хүүхдүүд хүнсний аюулгүй , орчин үеийн чанарын шаардлага хангасан хоол тэжээлээр хангагдах боломжтой болохын зэрэгцээ

Хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэр ашигтай ажиллаж улсаас жил бүр алданги авахгүйгээр үйлдвэрлэлээ зохион байгуулах нөхцөл бүрдэх болно.



ДАРГА 

Р.ЗОРИГТ .

ӨМНӨХ ӨГҮҮЛЭЛ

1989-2003

Улаанбаатар хотын Хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэр /ХСТҮ/ нь 1971 онд ЗХУ-с бэлэг болгон ашиглалтанд оруулж өгчээ.

Тус үйлдвэр нь байгуулагдсанаасаа эхлэн 1995 он хүртэл хоногт 5 тн сүү боловсруулж, 25000 нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэн нийслэлийн 10 мянган хүүхдэд үйлчлэхийн зэрэгцээ 30 гаруй ясли, 5 хүүхдийн больниц, сувилалд сүү, тараг, бусад бүтээгдэхүүнээр тасралтгүй хангаж ирж байжээ. Тус үйлдвэрээс гарч байгаа бүх бүтээгдэхүүн бүрэн боловсрогдон ариутгагдсан тул хүүхдэд шууд өгдгөөрөө онцлог байв.

Хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэр нь анх ашиглалтанд орохдоо түүхий эдээ УБ хотын сүүний үйлдвэрээс хангагдахаар зохион байгуулагдсан байв. Зах зээлд шилжсэнээр сүүний фирмүүд задарч олон өмчийн хэлбэрт орж сүү нийлүүлэлт эрс багассан, 1993 оноос импорт болон дотоодын түүхий эд материал, сэлбэг, түлш, эрчим хүч, уур, ус, тээврийн зардал, хөлс нэмэгдсэн зэргээс шалтгаалж бүтээгдэхүүний өртөг өндөржиж алдагдалтай ажиллах болжээ.

Нийслэлийн засаг даргын 2003 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн 429 тоот захирамжаар Хүүхдийн сүүн тэжээлийн нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгав.

Нийслэлийн өмчийн харилцааны газар, Нийслэлийн архивын албаны хооронд татан буугдсан Хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэрийн архивын баримтанд Эрдэм шинжилгээ техник боловсруулалт /ЭШТБ/ хийх гэрээ байгуулсаны дагуу 2003 оны 11 дүгээр сарын 20-ний хооронд архивч Д.Жаргалсүрэн, Т.Нарангэрэл нар ЭШТБ-ын ажил хийлээ.

Уг үйлдвэрийн баримтыг хүлээн авахад санхүүгийн 1994-2001 оны баримт, ажиллагсдын хувийн хэрэг хавтастай, бусад баримт нь анхан шатны боловсруулалт хийгдээгүй, баримтын нэр төрөл холилдсон, зарим бичиг эхлэл төгсгөлгүй баримтууд байлаа. Хамгийн ноцтой асуудал нь 1971-1993 оны даргын тушаал, мөн жилийн ажлын төлөвлөгөө, тайлан, хурлын протокол зэрэг байгууллагын үйл ажиллагааны гол баримт бичгүүд огт байхгүй байна.

Дээрх хүлээн авсан баримтнуудаас 1990-1994 оны цөөн тооны даргын тушаал, хурлын тэмдэглэл нийлүүлж бүрдүүлэв. Мөн байнгад орсон баримтуудыг дээрх задгай баримтнуудаас гаргаж олж хадгаламжийн нэгж бүрдүүллээ.

ЭШТБ-ын ажил хийсний үр дүнд:

- Байнга хадгалах 15 хадгаламжийн нэгж 1 бүртгэл
- 70 жил хадгалах 20 хадгаламжийн нэгж 1 бүртгэл

- Түр хадгалах 110 хадгаламжийн нэгж 1 бүртгэл
- Устгах бичгийн түүвэр жагсаалт /30 кг/ үйлдсэн.

Дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- Байнга хадгалах хадгаламжийн нэгж бүрдүүлэх
- Үдэж хавтаслах
- Хуудас дугаарлах
- Нүүр тэмдэг дарж, баталгаа бичих
- Нүүр бичилт хийж, дугаарлах
- Бүртгэл үйлдэх
- Түр хадгалах хадгаламжийн нэгжийг дугаарлаж, бүртгэл үйлдэх
- 1989-1993 оны цалин түүж, сарын дараалалд оруулах, хавтаслах
- Хувийн хэргийг үсгийн дараалалд оруулж, товъёог бичих
- Дугаар өгч, бүртгэл үйлдэх зэрэг ЭШТБ-ын ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Өмнөх өгүүлэл бичсэн:

Д. ЖАРГАЛСҮРЭН